

Бид 2002 онд анх танилцсан бөгөөд миний бие насанд хүрээгүй байх үед 2003 оноос хойш Б-ын зан харьцаа өөрчлөгдөж зэрлэг догшин авирлаж үг хэлээр доромжилж эд зүйлс эвдэлж сүйтгэх болон миний биед халдаж улмаар миний болон миний ойр дотны хүмүүсийн амь насанд заналхийлж намайг айлган сүрдүүлж нэгээс хоёр сарын давтамжтайгаар хүчирхийлдэг болсон. Энэ байдлаас болж миний бие Б тай уулзахгүй байх, салах оролдлогыг олон удаа хийсэн боловч тухай бүрд өөрийнхөө амийг егүүтгэнэ гэж гарынхаа судасыг ханах, хоолойгоо боох болон тагтаар үсрэхийг завдах оролдлогуудыг хийж байсан болохоор миний бие Б г амиа хорлох үйлдэл хийчих болов уу, эсвэл миний болон манай ар гэрийнхний (ээж аав, дүү нарын) амь нас энэ хүний гарт үрэгдэх вий хэмээн эмээдэг байсны улмаас одоог хүртэл тэвчиж ирсэн.

Энэ хооронд том хүү 2008 онд төрөөд Б-ын зан харилцаа засрах болов уу гэж бодож байтал засраагүй. Улмаар бага охин 2015 онд төрсөний дараа 2017оны 12 сард Америк улсад ирсэн. Миний ээж манай 2 хүүхдийг харж бидэнд туслахаар бидэнтэй хамт ирсэн юм.

Дээрх бүх хугацаанд бидний хоорондын харилцаа хүйтэн хөндий, байнгын хэрүүл маргаантай байдаг байсан ба миний бие хүүхдийн хажууд хэзээ ч маргалдахыг хүсдэггүй байсан учир хүлцэнгүй тэвчиж өнгөрөөдөг байсан. Харамсалтай нь Б нь хүүхдийн хажууд намайг үг хэлээр доромжилж надаар үг хэлүүлэх гэж хүүхдийн хажууд хэрүүл маргаан өдөж зэрлэг догшин авирлаж хүүхдүүдийг сэтгэл санааны хувьд хүнд байдалд оруулдаг байсан учир миний бие Б д хамт амьдрах хүсэлгүй болсон учираа сална гэдгийг удаа дараа хэлдэг байсан.

2021оны 5,6,7 саруудад Б тай хамтран амьдрахад тэвчихийн аргагүй байдлууд гаргаж шөнө орой эрүүл болон согтуудаа агсан тавьж намайг үүр цайтал унтуулахгүй сонсохыг хүссэн үгээ хэлүүлэх гэж дарамталж хариулахгүй болохоор намайг болон миний ар гэрийнхний (ээж дүү нарын) амь насанд заналхийлж айлган сүрдүүлэх, миний нүүрлүү халуун ус, халуун тос цацаад хэн ч тоохгүй болгоод өгч чадна шүү гэж заналхийлэн мөн гэр орны эд зүйлс эвдэлж зэрлэг догшин авирладаг байсан. Мөн 2 хүүхдийн талаар хэлэхдээ энэ 2 шээс миний хүүхэд биш аваад зайлаарай гэж байсан. Хамгийн сүүлд 7 сард надруу ширээ авч шидэж яг одоо наана чинь алчина шүү хэмээн үнэн сэтгэлээсээ хэлэхэд нь би маш их айж шөнөжин унтаж чадалгүй өглөө нь гэрээсээ гарч яваад ахиж эргэж очоогүй.

Намайг явсанаас хойш Б нь намайг буцааж аваачих зорилгоор миний ээж, аав, дүү болон хүүхдүүдээр дамжуулан надад нөлөөлөх гэж олон удаа янз бүрийн оролдлого хийсэн. Үүнд:

- Намайг өөртөйгөө буцаж нийлүүлэх зорилгоор миний талаар худал мэдээллийг ээж, аав, дүү нарт өгч миний эсрэг болгох оролдлого хийсэн
- Над руу янз бүрийн арга хэрэглэж мессеж бичиж амиа хорлохыг завдаж буй мэт сэтгэгдэл төрүүлж өрөвдүүлэх гэж оролдсоныг нь тоохгүй болохоор заналхийлсэн
- Хүү Би-г хамгийн сүүлийн удаа хамтдаа зургаа авахуулж, видео бичлэг хийе гэж амиа хорлох гэж байгаа хүн шиг хүүхдийн санааг зовоож надад дам нөлөөлөх гэж оролдсон
- Миний ээжийн хажууд хоолойгоо боомилох гэж худлаа дүр үзүүлж надад дам нөлөөлөх оролдлого хийсэн

-

- Миний ээжид хэлэхдээ хүү Би-г хоол бага идэж байна, хар тамхи хэрэглэж байгаа юм биш биз хэмээн худал хэлж надад дам нөлөөлөх оролдлого хийсэн

Энэ мэтчилэн надтай нийлэх гэсэн арга залиг нь хүлээж авахгүй болохоор Б нь аргаа өөрчилж хүүхдүүдийг ашиглах арга заль зохиож байгаа нь илтэд мэдэгдэж байна.

Энэ оны 9 сараас миний бие өөрийн ээж болон 2 хүүхэдтэйгээ тусдаа энгийн сайхан амар тайван аз жаргалтай амьдарч байсан боловч Б нь 9 сарын 11ний өдөр том хүү Би-г 7 өдөр авч хоноё гэхэд нь би зөвшөөрөөд явуулсан боловч одоог хүртэл хүүхдийг буцааж ирүүлээгүй. Хүү маань эцэгтэйгээ явах өдөр хүртэл надтай хамт баяр хөөртэй, аз жаргалтай энгийн сайхан байсан юм. Хүүгээ гэртээ ирэх болж байна уу гэж асуухад наана чинь ахиж хэзээ ч очихгүй, эцэгтэйгээ хамт амьдарна хэмээн зан харьцаа нь илтэд өөрчлөгдсөн нь анзаарагдаж хэзээ ч хүүхэд өөрөө сэтгэж бодож хэлэхээргүй, хүн зааж өгсөн мэт хэлсэн.

Мөн хүүхдийг хичээл сургуульд нь явах тал дээр анхаарахгүй байгаа талаар сургуулиас нь үе үе мэдэгдэл ирж байгаа.

Энэ хооронд хүүгийн минь сэтгэл санааг нь миний эсрэг болгож, намайг үзэн ядуулж надаас хөндийрүүлэх гэж хүүг минь өөрийн хэрэглүүр болгож тархийг нь худал мэддээлэлээр угааж надад нөлөөлөхөөр хүүхдээр мессеж бичүүлдэг болсон. Үүнд:

- Та миний ээж биш болж байгаа биз дээ
- Надад сургуульд явах сонирхол алга
- Хичээлтэй өдөр шөнө Зцагт унтсан гэсэн

Б нь охиныг нэг өдөр авч явсан өдөрөө надруу мессеж бичиж охиныг ашиглаж надад нөлөөлөх гэж оролдсон. Үүнд:

- Чамаас болж охин уйлж байна хэмээн худал ярьсан, Би охиныгоо гэртээ ирхэд нь миний охин яагаад уйлсан гэхэд шувуунаас айгаад уйлсан гэж үнэнгээ хэлсэн.

Дээр дурьдсан нөхцөл байдал, үйл явдалаас харахад Б нь өөрийн хүсэл зорилгыг хүчээр надад тулгаж намайг өөртэйгөө хүчээр хамт амьдрахыг хүлээн зөвшөөрүүлж, хэсэг хугацааны дараа надаас өс хонзон авах зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд ямар ч арга хэрэглэхээс буцахгүй болсон байна гэж үзэж байна. Миний бие Б-д анхнаасаа дургүй, ямар ч хайр сэтгэлгүй байсан ба гэнэн залуу насандаа худал хуурмаг үг, арга заль, айлган сүрдүүлэлт, хүчирхийлэлд нь хүчээр автаж хар дарсан зүүд шиг амьдарч явсаар өдий хүрсэн. Одоо би энэ хүнээс салж эрх чөлөөгөө эдэлж амар тайван аз жаргалтай тусдаа амьдарч байна.

Хамгийн харамсалтай нь Б нь өөрийн явцуу хүсэл зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд хүүхдүүдийг арга хэрэгсэл болгож хүүхдүүдийн сэтгэл санаа болон хичээл сурлага хүмүүжилд сөргөөр нөлөөлөх арга заль хэрэглэж байгаа нь миний сэтгэлийг маш их зовоож байна.

Иймд тус улсын хуулийн дагуу өөрийн эрх чөлөө болон хүүхдүүдийнхээ эдлэх эрхийг хангуулах болон гэр бүл цуцлуулах хүсэлтийг шүүхэд гаргаж байгааг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү.